



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

# **ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ**

**2026 оны 02 дугаар сар**

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 оны 03 сарын 16  
Улаанбаатар хот

# НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

## Үзүүлэлт

## Тодорхойлолт\*

<b>Тээсэн ачаа</b>	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
<b>Ачаа эргэлт</b>	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
<b>Тээсэн зорчигч</b>	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
<b>Зорчигч эргэлт</b>	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
<b>Шилжүүлсэн тн.км</b>	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
<b>Тээврийн орлого</b>	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

\*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

## ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БАЯНЗУЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГЭРЭЛНЯМ

## БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЭМЭХЖАРГАЛ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ<sup>1</sup> бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

<sup>1</sup> Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

## **АГУУЛГА**

<b>БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....</b>	<b>5</b>
1.1. АЧАА ТЭЭВЭР .....	6
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР .....	7
<b>БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР .....</b>	<b>8</b>
2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА .....	8
2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....	8
<b>БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР .....</b>	<b>9</b>
3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА .....	9
3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ .....	12
<b>БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР .....</b>	<b>13</b>
4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА .....	13
4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....	14
4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ .....	15
4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ .....	16
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ .....	17
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>18</b>

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	5
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	8
Хүснэгт 3. Автотээврийн зорчигч.....	8
Хүснэгт 4. Төмөр замын ачаа тээвэр.....	9
Хүснэгт 5. Төмөр замын зорчигч тээвэр.....	12
Хүснэгт 6. Агаарын тээврийн ачаа.....	13
Хүснэгт 7. Агаарын тээврийн зорчигч.....	14
Хүснэгт 8. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	15
Хүснэгт 9. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	16
Хүснэгт 10. Нислэг гүйцэтгэл.....	17

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	6
Зураг 2. Нийт экспорт.....	6
Зураг 3. Нийт импорт.....	6
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	7
Зураг 5. Олон улсад зорчигч.....	7
Зураг 6. Орон нутгийн зорчигч.....	7
Зураг 7. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	8
Зураг 8. Автотээврийн зорчигч.....	8
Зураг 9.Төмөр замын ачаа .....	9
Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	10
Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	10
Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	10
Зураг 13. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....	10
Зураг 14. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.07.31.....	11
Зураг 15. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	11
Зураг 16. Төмөр замын зорчигч тээвэр.....	12
Зураг 17. Төмөр замын зорчигч, хоногоор.....	12
Зураг 18. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	13
Зураг 19. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	13
Зураг 20. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	13
Зураг 21. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	14
Зураг 22. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	14
Зураг 23. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	15
Зураг 24. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар.....	16
Зураг 25. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	16
Зураг 26. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	17
Зураг 27. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	17

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2026 оны 02 дугаар сар

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ<sup>2</sup>

Хүснэгт 1



№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
				2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	5,945.9	11,989.6	6,622.1	17,108.9	42.7%
		Төмөр зам	мян.тн	3,154.9	6,898.4	4,249.1	9,545.4	38.4%
		Агаар	мян.тн	0.7	1.3	0.7	1.4	4.2%
		<b>Нийт ачаа</b>	<b>мян.тн</b>	<b>9,101.5</b>	<b>18,889.3</b>	<b>10,871.9</b>	<b>26,655.7</b>	<b>41.1%</b>
2	Дамжин өнгөрсөн ачаа	Төмөр зам	мян.тн	472.2	871.2	461.7	908.4	4.3%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	835.0	1,866.1	898.2	1,976.7	5.9%
		Автотээвэр	мян.тн	5,767.6	11,583.1	6,447.0	16,710.0	44.3%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>6,602.6</b>	<b>13,449.2</b>	<b>7,345.2</b>	<b>18,686.7</b>	<b>38.9%</b>
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	275.1	620.8	380.8	800.3	28.9%
		Автотээвэр	мян.тн	178.3	406.5	398.9	622.7	53.2%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>453.4</b>	<b>1,027.3</b>	<b>779.7</b>	<b>1,422.9</b>	<b>38.5%</b>
5	Дотоод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,572.6	3,540.3	2,508.3	5,859.9	65.5%
		Агаар	мян.тн	0.7	1.3	0.7	1.4	4.2%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>1,573.3</b>	<b>3,541.6</b>	<b>2,509.0</b>	<b>5,861.3</b>	<b>65.5%</b>
6	Ачаа эргэлт	Автотээвэр	сая тн.км	967.0	1,914.5	917.7	2,352.6	22.9%
		Төмөр зам	сая тн.км	1,637.9	3,406.0	1,902.6	4,103.0	20.5%
		Агаар	сая.тн.км	2.0	3.8	2.2	4.5	19.4%
		<b>Нийт</b>	<b>сая тн.км</b>	<b>2,606.9</b>	<b>5,324.3</b>	<b>2,822.5</b>	<b>6,460.1</b>	<b>21.3%</b>
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	12,720.5	25,582.0	13,311.3	28,231.1	10.4%
		Төмөр зам	мян.хүн	103.5	261.2	103.7	254.3	-2.6%
		Агаар	мян.хүн	141.0	331.2	150.8	360.9	9.0%
		<b>Нийт зорчигч</b>	<b>мян.хүн</b>	<b>12,964.9</b>	<b>26,174.4</b>	<b>13,565.8</b>	<b>28,846.3</b>	<b>10.2%</b>
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	19.7	53.6	10.8	40.8	-23.9%
		Төмөр зам	мян.хүн	1.8	5.1	1.6	4.9	-3.5%
		Агаар	мян.хүн	109.2	266.5	120.6	298.8	12.1%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>130.7</b>	<b>325.2</b>	<b>133.0</b>	<b>344.5</b>	<b>5.9%</b>
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	105.6	254.5	124.1	274.3	7.8%
		Төмөр зам	мян.хүн	101.7	256.1	102.1	249.4	-2.6%
		Агаар	мян.хүн	31.8	64.7	30.2	62.1	-4.0%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>239.1</b>	<b>575.3</b>	<b>256.4</b>	<b>585.8</b>	<b>1.8%</b>
10	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	12,595.1	25,273.9	13,176.4	27,916.0	10.5%
11	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн.км	119.5	272.4	128.4	284.3	4.4%
		Төмөр зам	сая хүн.км	43.3	110.8	40.1	108.5	-2.1%
		Агаар	сая хүн.км	366.8	921.7	402.8	999.8	8.5%
		<b>Нийт</b>	<b>сая хүн.км</b>	<b>529.6</b>	<b>1,304.9</b>	<b>571.3</b>	<b>1,392.6</b>	<b>6.7%</b>
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	808.0	1,923.0	894.0	2,220.0	15.4%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	684.0	1,312.0	655.0	1,324.0	0.9%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	5,509.0	11,919.0	6,490.0	13,796.0	15.7%

<sup>2</sup> Зам, тээврийн салбарын 2026 оны 2 дугаар сарын статистикийн мэдээг 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдөр гаргав.

### 1.1. АЧАА ТЭЭВЭР


Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2026 оны 2 дугаар сард 10.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 2 дугаар сартай харьцуулахад 19.5%-аар өссөн. Эхний 2 сарын байдлаар нийт 26.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2026 оны 2 дугаар сард автотээврээр 6.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 2 дугаар сартай харьцуулахад 11.4%-аар өссөн. Үүнээс экспортод 6.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 11.8%-аар өссөн бол импортоор 175.1 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 1.9%-аар буурсан үзүүлэлттэй байна. Харин эхний 2 сарын байдлаар 17.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.7%-аар өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2026 оны 2 дугаар сард 4.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.4%-аар өссөн. Харин өссөн дүнгээр буюу эхний 2 сарын байдлаар нийт 9.5 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оноос 38.4%-аар өссөн байна. Үүнээс дотоодын ачаа 5.9 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 65.5%-аар, дамжин өнгөрсөн ачаа 908.4 мянган тонн болж 4.3%-аар, импортын ачаа 800.3 мянган тонн болж 28.9%-аар, экспортын ачаа 1.9 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 5.9%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Агаарын тээврээр 2026 оны 2 дугаар сард 694.9 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 2 дугаар сартай харьцуулахад 0.03%-аар өссөн. Эхний 2 сарын байдлаар нийт 1378 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.2%-аар өссөн байна.



Экспортоор 2026 оны эхний 2 сард 18.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.9%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 1.9 сая тонн тээвэрлэсэн нь 5.9%-аар, автотээврээр 16.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 44.3%-аар тус тус өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 89%-ийг, төмөр зам 11%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2026 оны эхний 2 сард нийт 1.4 сая тонн болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.5%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 800.3 мянган тонн ачаа импортолсон нь 28.9%-аар, автотээврээр 622.7 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 53.2%-аар тус тус өссөн байна. Импортын тээврийн 56%-ийг төмөр замаар, 44%-ийг автотээврээр тээсэн байна. /Зураг 3/




## 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР


Бүх төрлийн тээврээр 2026 оны 2 дугаар сард 13.6 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны 2 дугаар сартай харьцуулахад 4.6%-аар өссөн. Эхний 2 сарын байдлаар 28.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 10.2%-аар өсжээ.

- 2026 оны 2 дугаар сард 13.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6%-аар өссөн байна. Үүнээс орон нутагт 124.1 мянган зорчигч (+17.5%), олон улсад 10.8 мянган зорчигч (-45.1%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.2 сая зорчигч (+4.6%) тус тус зорчсон байна. Эхний 2 сард нийт 28.2 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4%-аар өссөн байна. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замын тээврээр 2026 оны 2 дугаар сард нийт 103.7 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр нийт 254.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 2.6%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 4.9 мянган зорчигч зорчсон нь 3.5%-аар, орон нутагт 249.4 мянган зорчигч зорчсон нь 2.6%-аар тус тус буурчээ.
- Агаарын тээврээр оны 2 дугаар сард агаарын тээврээр нийт 150.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7%-аар өссөн байна. Өссөн дүнгээр нийт 360.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9%-аар өссөн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсын зорчигч



Олон улсад нийт 344.5 мянган зорчигч (+5.9%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 298.8 сая зорчигч (+12.1%), автотээврээр 40.8 мянган зорчигч (-23.9%), төмөр замаар 4.9 мянган зорчигч (-3.5%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 87%, автотээвэр 12%, төмөр зам 1%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 5/

Орон нутагт нийт 585.8 мянган зорчигч (+1.8%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 274.3 мянган зорчигч (+7.8%), төмөр замаар 249.4 мянган зорчигч (-2.6%), агаарын тээврээр 62.1 мянган зорчигч (-4.0%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 47%, төмөр зам 42%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



**БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР**

**2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА**

2026 оны эхний 2 сард авто замаар 17.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 42.7%-аар өслөө.

Хүснэгт 2


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
		2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
<b>Нийт ачаа</b>	<b>мян.тн</b>	<b>5,945,908.4</b>	<b>11,989,596.3</b>	<b>6,622,078.2</b>	<b>17,108,918.2</b>	<b>42.7%</b>
Импорт	мян.тн	178,264.8	406,492.9	175,125.2	398,895.5	-1.9%
Экспорт	мян.тн	5,767,643.6	11,583,103.4	6,446,953.0	16,710,022.7	44.3%
Ачаа эргэлт	сая тн.км	966.9	1,914.5	917.7	2,352.6	22.9%

2026 оны 2 дугаар сард автотээврээр 6.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 2 дугаар сартай харьцуулахад 11.4%-аар өссөн. Үүнээс экспортод 6.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 11.8%-аар өссөн бол импортоор 175.1 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 1.9%-аар буурсан үзүүлэлттэй байна. Харин эхний 2 сарын байдлаар 17.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.7%-аар өссөн байна.

Ачаа эргэлт 2 дугаар сард 917.7 сая тонн км болсон нь өмнөх оны 2 дугаар сартай харьцуулахад 5.1%-аар буурсан байна. Өссөн дүнгээр буюу эхний 2 сарын байдлаар 2,352.6 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.9%-аар өссөн байна.

Ачаа тээврийн 98%-ийг экспортын ачаа, 2%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа 99.8% эзэлж байгаа бол үүнээс нүүрс 96.7%-ийг эзэлж байна. /Зураг 7/


2026 оны 2 дугаар сард авто замаар 6.2 сая тонн нүүрс экспортод гарсан. Харин өссөн дүнгээр 16.1 сая тонн нүүрс автозамаар экспортод гарчээ.



**2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ**

Хүснэгт 3

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
		2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
<b>Нийт зорчигч</b>	<b>хүн</b>	<b>12,720,450.0</b>	<b>25,581,978.0</b>	<b>13,311,289.0</b>	<b>28,231,097.0</b>	<b>10.4%</b>
Олон улсад	хүн	19,710.0	53,606.0	10,815.0	40,807.0	-23.9%
Орон нутагт	хүн	105,649.0	254,482.0	124,096.0	274,312.0	7.8%
Хот доторх нийтийн тээвэр	хүн	12,595,091.0	25,273,890.0	13,176,378.0	27,915,978.0	10.5%
Зорчигч эргэлт	сая хүн.км	119.5	272.4	128.4	284.3	4.4%



Автотээврээр 2026 оны 2 дугаар сард 13.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6%-аар өссөн байна. Үүнээс орон нутагт 124.1 мянган зорчигч (+17.5%), олон улсад 10.8 мянган зорчигч (-45.1%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.2 сая зорчигч (+4.6%) тус тус зорчсон байна.

Эхний 2 сард нийт 28.2 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4%-аар өссөн байна.

Автотээврийн зорчигчийн 98.7%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.0%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 8/

**БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР**

**3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА**


**Төмөр замын тээврээр 2026 оны эхний 2 сард 9.5 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.4%-аар өслөө.**

Хүснэгт 4


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралты % 2026/2025
		2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
<b>Ачаа тээвэрлэлт</b>	<b>мян.тн</b>	3,154.9	6,898.4	4,249.1	9,545.4	38.4%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	2,620.5	5,568.3	2,867.1	6,042.5	8.5%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	116.9	302.6	722.8	1,951.2	544.9%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	96.9	321.9	-	-	-
"Монголиантранс Ложистик" ХХК	мян.тн	298.6	607.3	290.4	590.8	-2.7%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	22.0	98.4	368.8	960.9	876.9%
Дотоодын ачаа	мян.тн	1,572.6	3,540.3	2,508.3	5,859.9	65.5%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	1,038.2	2,210.2	1,126.3	2,357.0	6.6%
үүнээс "Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	116.9	302.6	722.8	1,951.2	544.9%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	96.9	321.9	-	-	-
"Монголиантранс Ложистик" ХХК	мян.тн	298.6	607.3	290.4	590.8	-2.7%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	22.0	98.4	368.8	960.9	876.9%
Импорт ачаа	мян.тн	275.1	620.8	380.8	800.3	28.9%
БНХАУ-аас	мян.тн	60.6	132.6	118.0	262.9	98.3%
ОХУ-руу	мян.тн	214.5	488.2	262.9	537.5	10.1%
Экспорт ачаа	мян.тн	835.0	1,866.1	898.2	1,976.7	5.9%
БНХАУ-руу	мян.тн	823.5	1,840.8	883.0	1,952.9	6.1%
ОХУ-руу	мян.тн	11.6	25.4	15.3	23.9	-6.2%
Дамжин өнгөрөх ачаа	мян.тн	472.2	871.2	461.7	908.4	4.3%
БНХАУ-аас ОХУ-руу	мян.тн	154.9	275.2	153.9	313.8	14.0%
ОХУ-аас БНХАУ-руу	мян.тн	317.4	596.0	307.8	594.6	-0.2%
Ачаа эргэлт	сая.тн-км	1,637.9	3,406.0	1,902.6	4,103.0	20.5%

Төмөр замын тээврээр 2026 оны 2 дугаар сард 4.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.4%-аар өссөн. Харин өссөн дүнгээр буюу эхний 2 сарын байдлаар нийт 9.5 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оноос 38.4%-аар өссөн байна. Үүнээс дотоодын ачаа 5.9 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 65.5%-аар, дамжин өнгөрсөн ачаа 908.4 мянган тонн болж 4.3%-аар, импортын ачаа 800.3 мянган тонн болж 28.9%-аар, экспортын ачаа 1.9 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 5.9%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 4/

**Зураг 9. Төмөр замын ачаа, мян.тн**




**Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь**




2026 оны 2 дугаар сарын байдлаарх нийт ачаа тээврийн 6 сая тонн буюу 63%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 1.9 сая тонн буюу 21%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 590.8 мянган тонн буюу 6%-ийн ачааг "Монголиантранс Ложистик" ХХК, 960.9 мянган тонн ачаа буюу нийт ачааны 10%-ийг "Монголиантранс Лайн" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 10/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 5.9 сая тонн буюу 61%-ийг дотоодын ачаа, 1.9 сая тонн буюу 21%-ийг экспортын ачаа, 908.4 мянган тонн буюу 10%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 800.3 сая тонн буюу 8%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 11/

**Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл**




**Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь**




Дотоодод тээвэрлэсэн 5.9 сая тонн ачааны 2.4 сая тонн ачаа буюу 40%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 1.9 сая тонн буюу 33%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 590.8 мянган тонн ачаа буюу 10%-ийг "Монголиантранс Ложистик" ХХК, 960.9 сая тонн буюу 17%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 12/

2026 оны эхний 2 сарын байдлаар байгууллагуудын ачаа тээврийн хоногийн дундажийг тооцоход "УБТЗ" ХНН хоногт дунджаар 102.4 мянган тонн, "МТЗ" ТӨХК нь 33.1 мянган тонн, "МТЛожистик" ХХК нь 10 мянган тонн, "МТЛайн" ХХК нь 16.3 мянган тонн ачаа тээвэрлэж байна. /Зураг 13/

**Зураг 13. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар**




Зураг 14. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2026.01.31



Төмөр замын байгууллагуудаар өдөр бүр тээвэрлэсэн ачааны хэмжээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос оруулав. 2026 оны 2 сарын байдлаар өдөрт дундажаар орон нутгийн ачаа 99.3 мянга, экспортын ачаа 33.5 мянга, дамжин өнгөрсөн ачаа 15.4 мянга, импортод дундажаар 13.6 мянган ачаа тээвэрлэсэн байна. /Зураг 14/

Зураг 15 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор




2025.01.01-2026.02.28-ны өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг 15/

3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 5

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
		2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
<b>Зорчигч тээвэрлэлт</b>	<b>мян.хүн</b>	103.5	261.2	103.7	254.3	-2.6%
Олон улс	мян.хүн	1.8	5.1	1.6	4.9	-3.5%
Орон нутаг	мян.хүн	101.7	256.1	102.1	249.4	-2.6%
Зорчигч эргэлт	сая хүн.км	43.3	110.8	40.1	108.5	-2.1%


Зураг 16. Төмөр замын зорчигч тээвэр



2026 оны 2 дугаар сард нийт 103.7 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр нийт 254.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 2.6%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 4.9 мянган зорчигч зорчсон нь 3.5%-аар, орон нутагт 249.4 мянган зорчигч зорчсон нь 2.6%-аар тус тус буурчээ.

Зорчигч эргэлт 2 дугаар сард 40.1 сая хүн км болсон нь өмнөх оны 2 дугаар сараас 7.4%-аар буурсан. Эхний 2 сарын дүнгээр 108.5 сая хүн км болсон нь өмнөх оны мөн үеэс 2.1%-аар бууржээ. /Зураг 16/

Зураг 17. Төмөр замын зорчигч, хоногоор




2025.01.01-2026.02.28-ны өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформоос нэгтгэн гаргав. 2026 оны 2 сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 4.3 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 17/

**БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР**

**4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА**

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
			2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
1	<b>Нийт ачаа, шуудан тээвэр</b>	тн	694.7	1,322.0	694.9	1,378.0	4.2%
2	олон улсад	тн	692.1	1,317.6	692.0	1,370.1	4.0%
3	орон нутагт	тн	2.6	4.4	2.9	7.9	81.8%
4	<b>Нийт ачаа</b>	тн	676.8	1,286.4	678.5	1,347.7	4.8%
5	олон улсад	тн	674.2	1,282.0	675.6	1,339.8	4.5%
6	орон нутагт	тн	2.6	4.4	2.9	7.9	81.6%
7	<b>Нийт шуудан</b>	тн	17.9	35.6	16.4	30.3	-14.9%
8	олон улсад	тн	17.9	35.6	16.4	30.3	-14.9%
9	орон нутагт	тн	0.0	0.0	0.0	0.0	-
10	<b>Ачаа, шуудан эргэлт</b>	мян.тн-км	2,003.9	3,767.7	2,203.7	4,498.1	19.4%
11	олон улсад	мян.тн-км	2,002.6	3,765.4	2,202.2	4,493.7	19.3%
12	орон нутагт	мян.тн-км	1.3	2.3	1.5	4.4	91.3%



Агаарын тээврээр 2026 оны 2 дугаар сард 694.9 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.03%-аар өссөн. Үүнээс ачаа 678.5 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 0.2%-аар өссөн бол шуудан 30.3 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8.2%-аар буурсан байна. /Зураг 18/

Эхний 2 сарын байдлаар нийт 1378 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.2%-аар өссөн байна.


Олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан эхний 2 сарын байдлаар 1370.1 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 4%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 7.9 тонн болж өмнөх оны мөн үеэс 1 дахин тус тус өссөн байна. /Зураг 19/

Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.3%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.7%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 98%-ийг ачаа эзэлж байгаа бол 2%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2026 оны эхний 2 сард 4.5 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 19.4%-аар өсжээ.



**Зураг 20. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар**




#### 4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2026 оны эхний 2 сард нийт 360.9 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 9%-аар өслөө.

Хүснэгт 7

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
		2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
<b>Нийт зорчигч</b>	<b>хүн</b>	140,972	331,236.0	150,789	360,905.0	9.0%
Олон улсад	хүн	109,214	266,546.0	120,568	298,805.0	12.1%
Орон нутагт	хүн	31,758	64,690.0	30,221	62,100.0	-4.0%
<b>Зорчигч эргэлт</b>	<b>мян.хүн км</b>	366,816.7	921,737.8	402,794.5	999,832.9	8.5%
Олон улсад	мян.хүн км	348,113.1	883,744.6	385,273.7	963,559.6	9.0%
Орон нутагт	мян.хүн км	18,703.6	37,993.2	17,520.8	36,273.3	-4.5%




2026 оны 2 дугаар сард агаарын тээврээр нийт 150.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 120.6 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 10.4%-аар өссөн бол орон нутагт 30.2 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 4.8%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Өссөн дүнгээр нийт 360.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9%-аар өссөн байна. /Хүснэгт 7/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна. /Зураг 22/

**Зураг 22. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар**




Зорчигч эргэлт 2026 оны 2 дугаар сард 402.8 сая хүн км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8%-аар өссөн. Харин өссөн дүнгээр буюу эхний 2 сарын байдлаар 999.8 сая хүн км болж өмнөх оны мөн үеэс 8.5%-аар өссөн байна.

4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 8


№	Үзүүлэлт	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
		2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
1	<b>Олон улсад</b>	109,214	266,546.0	120,568	298,805.0	12.1%
2	чиглэл Сөүл	33,017	74,532	40,186	86,315.0	15.8%
3	Бээжин	14,122	37,308	13,290	39,865.0	6.9%
4	Фукуок	7,874	18,396	10,400	22,752.0	23.7%
5	Токио	7,951	18,704	8,201	17,775.0	-5.0%
6	Истанбул	7,727	17,135	7,957	17,200.0	0.4%
7	ХонКонг	4,517	9,729	5,449	10,967.0	12.7%
8	Хөх хот	4,630	11,133	4,784	10,855.0	-2.5%
9	Санья/Хайнань	5,044	17,455	4,641	17,697.0	1.4%
10	Бангкок	4,375	9,923	4,233	13,238.0	33.4%
11	Франкфурт	2,602	7,120	3,799	11,351.0	59.4%
12	Эрээн		-	3,011	7,211.0	-
13	Пукет	2,806	8,340	3,008	7,689.0	-7.8%
14	Ордос	4,071	8,986	2,346	6,082.0	-32.3%
15	Сингапур		-	2,243	7,047.0	-
16	Хо Ши Мин	1,669	3,373	1,458	3,057.0	-9.4%
17	На Транг	1,148	2,386	1,239	2,144.0	-10.1%
18	Хайлаар/Хөлөнбуйр	619	3,585	1,084	3,931.0	9.7%
19	Алмата	1,318	3,211	1,074	2,020.0	-37.1%
20	Шанхай		-	895	2,589.0	-
21	Ханой	753	1,891.0	722	1,936.0	2.4%
22	Бусад чиглэлд	4,971	13,339	548	7,084	-46.9%

Зураг 23. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



2026 оны эхний 2 сарын байдлаар олон улсад нийт 298.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.1%-аар өссөн. Хамгийн их зорчигч зорчсон Сөүл чиглэлд 86.3 мянган зорчигч (+15.8%), Бээжин хотруу 39.9 мянган зорчигч (+6.9%), Токио чиглэлд 22.8 мянган зорчигч (+23.7%), Истанбул чиглэлд 17.8 мянган зорчигч (-5%), Фукуок чиглэлд 17.7 мянган зорчигч (+1.4%), ХонгКонг чиглэлрүү 17.2 мянган зорчигч (+0.4%), Хөх хот чиглэлд 13.2 мянган зорчигч (+33.4%), Санья чиглэлд 11.4 мянган зорчигч (+59.4%), Бангкок чиглэлд 10.9 мянган зорчигч (-2.5%) тус тус тээвэрлэсэн байна. Ордос, Хөх хот, Санья/Хайнань, Эрээн чиглэлд зорчигчийн тоо эрс нэмэгдсээр байна. Дээрх графикт 2026 онд хамгийн их зорчигч зорчсон 20 хотуудыг харуулав. /Зураг 23/

Зураг 24. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар




Олон улсад зорчсон зорчигчдын 47% буюу 141.1 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нислэгээр ниссэн бол “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 40.7 мянга, “Айрчайна”-ийн нислэгээр 26.4 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 27.2 мянга, “Корейн айр”-ийн нислэгээр 23.6 мянга, Туркиш айр нислэгээр 11.6 мянга, Жэжү айр нислэгээр 8.8 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 7.8 мянга, Чайна юнайтед эйрлайнс нислэгээр 3.3 мянга, Жуньёо айр нислэгээр 4.2 мянга, Ираеро нислэгээр 2.1 мянган зорчигч, Вьетжет айр нислэгээр 1.8 мянга, Красавиа нислэгээр 186, захиалгат нислэгээр 11 зорчигч тус тус олон улсад зорчсон байна. /Зураг 24/

#### 4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 9

№	Үзүүлэлт	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
		2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
1	<b>Орон нутагт зорчигч тээвэр</b>	31,758	64,690.0	30,221	62,100.0	-4.0%
2	чиглэл Оюутолгой	27,377	55,828.0	25,135	51,998.0	-6.9%
3	Ховд	1,320	2,461.0	1,321	2,471.0	0.4%
4	Өлгий	1,038	2,199.0	1,005	2,070.0	-5.9%
5	Улаангом	551	1,050.0	485	1,015.0	-3.3%
6	Улиастай	493	1,046.0	499	1,069.0	2.2%
7	Мөрөн	487	1,026.0	745	1,492.0	45.4%
8	Алтай	492	1,080.0	434	887.0	-17.9%
9	Баянхонгор			446	947.0	-
10	Бусад чиглэлд			151	151	-


Зураг 25. Орон нутгийн зорчигч, чиглэлээр



2026 оны 2 дугаар сард орон нутагт 30.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8%-аар буурсан байна.

Харин өссөн дүнгээр эхний 2 сард 62.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4%-аар буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү бууралтад Оюутолгой чиглэлд 52 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 6.9%-аар буурсан нь голлон нөлөөлжээ. /Хүснэгт 9/

**Зураг 26. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь**



Орон нутагт зорчигчдын 62% буюу 38.5 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 25% буюу 15.4 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 13% буюу 8.2 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутагт “МИАТ” ХХК-ийн зорчигч 8.9%-аар буурсан бол “Аэро Монголиа” ХХК зорчигч 0.2%-аар, “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 16.5%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 26/


### 4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 10

Үзүүлэлт	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025
	2 дугаар сар	Өссөн дүн	2 дугаар сар	Өссөн дүн	
<b>Нийт нислэгийн тоо</b>	7,001	15,154.0	8,039	17,340.0	14.4%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	5,509	11,919.0	6,490	13,796.0	15.7%
Хөөрөлт, буулт	1,492	3,235.0	1,549	3,544.0	9.6%
Олон улсын хөөрөлт, буулт	808	1,923.0	894	2,220.0	15.4%
Орон нутгийн хөөрөлт, буулт	684	1,312.0	655	1,324.0	0.9%

2026 оны 2 дугаар сард нийт нислэгийн тоо 8 мянга болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.8%-аар өссөн байна. Эхний 2 сарын байдлаар нийт нислэгийн тоо 17.3 мянга болж өмнөх оны мөн үеэс 14.4%-аар өссөн. Үүнээс олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 14.8 мянга болж 15.7%-аар, олон улсын хөөрөлт, буулт 2.2 мянга болж 15.4%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 1.3 болж 0.9%-аар тус тус өссөн байна. /Зураг 27/

**Зураг 27. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар**



## ДҮГНЭЛТ

### Ачаа тээвэр

2026 оны эхний хоёр сарын байдлаар улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр **26.7 сая тонн ачаа тээвэрлэсэн** нь өмнөх оны мөн үеийнхээс **7.8 сая тонн буюу 41.1 хувиар өссөн** үзүүлэлттэй байна. Үүнээс экспорт 38.9%-аар, импорт 38.5%-аар, дотоодын ачаа 65.5%-аар, дамжин өнгөрсөн ачаа 4.3%-аар тус тус нэмэгдсэн байна.

Тээврийн төрлөөр авч үзвэл автотээврээр эхний 2 сард 17.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.7%-аар, төмөр замын тээврээр эхний 2 сард 9.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.4%-аар тус тус өссөн байна.

Энэ нь тээврийн салбарын үйл ажиллагаа эрчимжиж, экспорт, импорт дотоодын бараа эргэлт эрчимжиж эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнийг илтгэж байна.

Гэхдээ өмнөх хоёр сарын (11, 12 сар) үзүүлэлттэй харьцуулахад нийт тээвэрлэсэн ачаа 5.3 сая тонн буюу 16.6%-аар буурсан нь улирлын шинж чанар, цаг агаарын нөхцөл болон баярын өдрүүдийн нөлөөтэй холбоотой байх боломжтой бөгөөд богино хугацаанд хэлбэлзэл ажиглагдаж байгааг харуулж байна.

Өсөлтийн хурд харьцангуй бага байгаа **төмөр замын дамжин өнгөрөх болон экспортын тээвэрлэлтийн хэмжээнд** анхаарах шаардлагатай байна. Ялангуяа олон улсын худалдаа болон логистикийн урсгал нэмэгдэж байгаа нөхцөлд дамжин өнгөрөх тээвэр, экспортын тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх нь тээврийн салбарын нийт өсөлтийг дэмжих чухал хүчин зүйл болох юм. Иймд цаашид дамжин өнгөрөх тээврийн урсгалыг нэмэгдүүлэх, экспортын тээврийн логистикийн үр ашиг, боомтын нэвтрүүлэх чадварыг сайжруулах чиглэлд бодлогын түвшинд анхаарал хандуулах шаардлагатай байна.

### Зорчигч тээвэр

Бүх төрлийн тээврээр 2026 оны эхний 2 сарын байдлаар давхардсан тоогоор **28.8 сая зорчигч** зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **2.7 сая зорчигчоор буюу 10.2%-аар өсжээ**. Тээврийн төрлөөр авч үзвэл автотээврээр 10.4%-аар, агаарын тээврээр 9.0%-аар тус тус өссөн бол төмөр замын тээврээр зорчсон зорчигчийн тоо 2.6%-аар буурсан байна.

Энэхүү өсөлтөд **нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийн тоо 10.5 хувиар өссөн** нь голлон нөлөөлсөн бөгөөд хотын хөдөлгөөний эрчим, нийтийн тээврийн хэрэглээ нэмэгдэж байгааг илтгэж байна. Цаашид хүн амын төвлөрөл болон хотын дэд бүтцийн хөгжлөөс шалтгаалан нийтийн тээврийн зорчигчийн урсгал тогтвортой өсөх хандлагатай байгаа тул нийтийн тээврийг хөгжүүлэх шаардлагатай.

Агаарын тээврийн зорчигчийн урсгал тогтвортой өсөх хандлагатай байгаа нь олон улсын зорчих хөдөлгөөн идэвхжиж, агаарын тээврийн үйлчилгээний эрэлт нэмэгдэж байгааг харуулж байна. Энэ нь аялал жуулчлал, бизнесийн зорчих урсгал болон нислэгийн чиглэл, давтамж нэмэгдэж байгаатай холбоотой байх боломжтой. Гэхдээ орон нутгийн зорчигчийн тоо харьцангуй бага байгаа тул нэмэгдүүлэх талаас бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн авах хэрэгтэй.

Төмөр замын зорчигч тээвэрлэлт тогтмол буурч байгаа нь тус салбарын үйлчилгээний чанар, хурд, хүртээмж болон өрсөлдөх чадвартай холбоотой байж болзошгүй юм. Иймд цаашид зорчигчийн үйлчилгээний чанарыг сайжруулах, галт тэрэгний хурд болон цагийн хуваарийг оновчтой болгох, тасалбарын уян хатан үнийн бодлого хэрэгжүүлэх, мөн дэд бүтэц, техникийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.